
Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар: Монгол Улсад хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхөд шаардлагатай нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоо, арга хэрэгслийг боловсруулах

1. Үндэслэл

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, сайн сайхан байдлыг хангах нь үндэсний хэмжээнд тэргүүлэх зорилгуудын нэг юм. Хууль эрх зүйн орчин болон институцийн хөгжилд ахиц дэвшил гарсан ч хүүхэд хамгааллын салбарт үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх, ил тод байдлыг хангахад саад бэрхшээлүүд байна. Иргэд, иргэний нийгэм, олон нийтийн зүгээс төрийн үйлчилгээнд хяналт тавьж, түүнд нөлөөлдөг нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоо нь хүүхэд хамгааллын бодлогыг зохих ёсоор хэрэгжүүлэх, нөөц бололцоогоор хангахад чухал арга зүй болох юм.

Энэхүү Зөвлөх үйлчилгээ нь Хүүхэд хамгаалаллын салбарт оролцоонд суурилсан засаглал, төсвийн ил тод байдлыг нэвтрүүлэхийн тулд Нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд нэвтрүүлэх арга зүй, холбогдох удирдамжийг боловсруулахад оршино. Эдгээр арга зүй нь иргэний нийгмийн байгууллага (ИНБ), орон нутгийн иргэд, институцийн оролцогч талуудад хүүхэд хамгааллын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын хяналтанд оролцох боломжийг олгоно.

Энэхүү санаачилга нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, хүүхэд хамгааллын үндэсний хууль тогтоомж, иргэдийн оролцоотой засаглалыг дэмжсэн төвлөрлийг сааруулах шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтуудтай нийцэж байгаа юм.

Хүүхдийг Ивээх Сан сүүлийн 30 гаруй жилийн турш Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирлээ. 1990-ээд оны эхээр үйл ажиллагаагаа эхэлснээс хойш Хүүхдийг Ивээх Сан нь хүүхэд хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн эрхийн засаглалыг бэхжүүлэх чиглэлд олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн. Тус байгууллага нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх, нийгмийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүдийг дэмжих чиглэлээр төрийн байгууллага, иргэний нийгэм, олон нийттэй хамтран ажилласан арвин туршлагатай билээ.

ХИС-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлийг www.savethechildren.mn цахим хуудсаас авна уу.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд халамжийн хувилбарт үйлчилгээ хөгжүүлэх, хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх, хүүхдийг онлайн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах чиглэлээр шинэлэг ажлуудыг гүйцэтгэсэн. Тус байгууллага нь хууль тогтоомжийн шинэчлэлд идэвхтэй оролцож, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлж, хот, хөдөө орон нутагт олон нийтэд түшиглэсэн хүүхэд хамгааллын механизмыг дэмжин ажилласан байна. ХИС нь нотолгоонд суурилсан нөлөөллийн ажил болон олон нийтийн оролцоогоор дамжуулж Монгол улсад хүүхэд хамгааллын талаарх хандлагыг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэж, хүртээмжтэй, хүний эрхэд суурилсан, орон нутгаас санаачилсан шийдлүүдийг нэн тэргүүнд онцолж ирсэн.

Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь ХИС-гийн олон жилийн туршлага дээр үндэслэн төрийн сангийн менежментийг хүүхэд хамгааллын зорилготой уялдуулах шинэ механизмыг боловсруулж, нэвтрүүлэх явдал юм. Хүүхдийг Ивээх Сан нь төсөв боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дэмжих замаар хүүхдийн хэрэгцээ, эрхийг засаглалын бүх түвшинд зохих ёсоор тусгаж, нөөц бололцоогоор хангахыг зорьж байна.

2. Зөвлөх үйлчилгээний гол зорилго

Зөвлөх үйлчилгээний гол зорилго нь Монгол Улсад хүүхэд хамгааллын төсөв боловсруулах, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг ил тод, иргэдийн оролцоог хангасан, хариуцлагатай болгоход чиглэсэн нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоо болон дагалдах арга зүй, хэрэгслүүдийг хөгжүүлэхэд оршино.

Зорилтууд:

- Үндэсний болон орон нутгийн түвшинд хүүхэд хамгааллын төсөв боловсруулахад иргэдийн оролцоог хангах өнөөгийн механизмыг судалж, үнэлэх
- Хүүхэд хамгааллын төлөвлөлт, санхүүжилтийн үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломжит арга замуудыг тодорхойлох
- Бодит нөхцөл байдалд тохирсон Нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоог боловсруулах
- Иргэний нийгэм, орон нутгийн засаг захиргаа, иргэдэд зориулж уг тогтолцоог бодит амьдралд хэрхэн ашиглаж болохыг тайлбарласан гарын авлага, бусад нэмэлт материалуудыг боловсруулах
- Ажил гүйцэтгэх арга барил, чадавхи бэхжүүлэх талаар зөвлөмж өгөх

3. Ажлын цар хүрээ, үүрэг даалгавар

Багийн бүрэлдэхүүн:

Зөвлөх үйлчилгээг дараах хоёр хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэнэ:

- Багийн ахлагч – Хүүхэд хамгаалал, нийгмийн ажлын мэргэжилтэн

- Судлаач – Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Үүрэг, хариуцлага:

Багийн ахлагч – Хүүхэд хамгаалал, нийгмийн ажлын мэргэжилтэн

- Нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоог боловсруулах ажлыг удирдан явуулна.
- Хүүхэд хамгааллын асуудлаар төр, ИНБ, иргэдтэй уулзаж, зөвлөлдөнө.
- Хүүхдийн эрхэд суурилсан арга зүйг уг тогтолцоо, арга хэрэгсэл боловсруулахад ашиглана.
- Монгол Улсын хууль эрх зүйн, институцийн, стратеги бодлогын бодит байдлыг уг тогтолцоонд тусгана.
- Ажлын ерөнхий явц, цаг хугацаа, багийн гишүүдийн үүрэг хариуцлагыг хянаж, зохицуулна.

Судлаач – Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

- Хүүхэд хамгааллын чиглэлээр улсын болон орон нутгийн хэмжээнд төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын үйл явцад дүн шинжилгээ хийнэ.
- Төсвийн мөчлөгт үнэлгээ хийж, ил тод байдал, хариуцлага дутагдаж буй хэсгүүдийг илрүүлж, тодорхойлно.
- Иргэдийн оролцоотой төсөв боловсруулах, төсвийн зарцуулалтыг шалгах, төрийн сангийн удирдлагыг хянахад зориулсан арга хэрэгслүүдийг бий болгоно.
- Санхүүгийн хариуцлагыг тайлбарласан гарын авлага болон нэмэлт материалуудыг боловсруулахад оролцоно.

Хамтын үүрэг хариуцлага

- Баримт бичгүүдийг судалж, орон нутгийн оролцогч талуудтай уулзаж, зөвлөлдөнө.
- Зөвлөх үйлчилгээний бүтээгдэхүүнийг ноорог болон эцсийн хувилбараар гаргаж, баталгаажуулна.
- Гүйцэтгэсэн ажлаа оролцогч талууд болон түнш байгууллагуудад танилцуулж, зөвлөмж өгнө.

4. Боловсруулах материалууд

Ажлын даалгаварт заасан хугацаанд англи, монгол хэл дээр дараах материалуудыг бэлтгэж ирүүлнэ.

Гүйцэтгэх ажил	Тайлбар	Хугацаа
Эхлэлийн тайлан	Арга зүй, баримт бичгийн судалгаа, ажлын төлөвлөгөө, оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө, Монгол Улсад болон дэлхийн хэмжээнд ижил төстэй үйл ажиллагааны талаар	1-р долоо хоногийн эцэст

	хийсэн судалгаа шинжилгээний хураангуй; одоогийн хууль эрх зүйн хүрээнд зөвлөх үйлчилгээг хэрхэн үр дүнтэй үзүүлэх тухай зөвлөмж. (Монгол, Англи хэл дээр бэлтгэх)	
Оролцогч талуудын зөвлөгөөний хураангуй	Засгийн газар, иргэний нийгэм, олон нийтийн бүлгүүдтэй хийсэн зөвлөгөөний хураангуй (Монгол хэл дээр бэлтгэх)	3-р долоо хоногт
Нийгмийн эгэх хариуцлагын тогтолцооны төсөл	Хүүхэд хамгааллын төсөв боловсруулах үйл явцад нээлттэй, хүртээмжтэй оролцоог хангах нарийвчилсан загвар. (Монгол, Англи хэл дээр бэлтгэх)	4-5-р долоо хоногт
Гарын авлага, нэмэлт материалуудын ноорог хувилбар	Хүүхэд хамгааллын төсөв боловсруулахад зориулсан гарын авлага, бусад нэмэлт материалууд. (Монгол хэл дээр бэлтгэх)	6-р долоо хоногт
Баталгаажуулах семинар	Арга хэрэгслүүдийг хянаж, баталгаажуулах зорилгоор оролцогч талуудын семинар зохион байгуулах. (Монгол хэл дээр бэлтгэх)	7-р долоо хоногт
Эцсийн тайлан, бүтээгдэхүүн	Шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулсан тогтолцоо, гарын авлага, семинарын тайлан. Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан уг ажлыг цаашид хэрхэн үр дүнтэй үргэлжлүүлэх талаар зөвлөмж оруулах. (Монгол, Англи хэл дээр бэлтгэх)	8-р долоо хоногийн эцэст

5. Хугацаа

Зөвлөх үйлчилгээ нь 2025 оны 08-р сарын 25-наас 2025 оны 10-р сарын 17-ний хооронд 8 долоо хоногийн хугацаатай хэрэгжинэ. Уг зөвлөх үйлчилгээний хүрээнд шаардлагатай бол газар дээр нь очиж танилцах, онлайн уулзалт хийх, биечлэн уулзаж, ярилцана.

6. Зөвлөхүүдэд тавигдах шаардлага

Багийн ахлагч – Хүүхэд хамгааллын мэргэжилтэн:

- Нийгмийн ажил, хүүхэд хамгаалал эсвэл холбогдох чиглэлээр мэргэшсэн, өндөр зэрэгтэй байх
- Хүүхдийн эрх, нийгмийн ажил, олон нийтийн хөгжлийн чиглэлээр 7-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Иргэдийн оролцоотой бодлого боловсруулах, оролцогч талуудын оролцоог хангасан туршлагатай байх

- Монгол, англи хэл дээр бичиг баримтыг мэргэжлийн түвшинд боловсруулах чадвартай байх

Судалгааны ажилтан – Санхүү, төсөв хариуцсан мэргэжилтэн:

- Төрийн удирдлага, эдийн засаг, санхүү болон холбогдох чиглэлээр мэргэшсэн, өндөр зэрэгтэй байх
- Улсын төсөв, нийгмийн үйлчилгээний зарцуулалтын дүн шинжилгээ эсвэл төрийн сангийн удирдлагын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Нийгмийн салбар, ялангуяа хүүхэдтэй холбоотой хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж байсан туршлагатай байх
- Монгол, англи хэл дээр бичиг баримтыг мэргэжлийн түвшинд боловсруулах чадвартай байх

7. Бүрдүүлэх материал

Сонирхсон багууд доорх бичиг баримтыг 2025 оны 08-р сарын 15-ний өдөр багтаан ирүүлнэ үү.

1. Зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэх сонирхлыг илэрхийлсэн захидал. Уг бичиг нь дараахь шаардлагыг хангасан байх ба Монгол, Англи хэл дээр ирүүлэх:
 - Гүйцэтгэх ажлын талаар ойлголттой байгаагаа харуулсан байх
 - Ажил гүйцэтгэх арга зүйгээ тайлбарлаж, төлөвлөгөөг нарийвчлан тусгасан байх
 - Зөвлөхүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байх
2. Зөвлөхүүдийн туршлага, мэргэжлийг тусгасан танилцуулгыг (CV). Монгол юмуу Англи хэл дээр ирүүлэх
3. Өмнө гүйцэтгэж байсан ижил төстэй ажлын материалууд (жишээ нь, өмнө боловсруулж байсан стратеги, хүрээ, арга хэрэгсэл, тайлан, зөвлөмж). Монгол юмуу Англи хэл дээр ирүүлэх.
4. Зөвлөх үйлчилгээний хөлс, бусад зардлыг багтаасан үнийн санал. Монгол юмуу Англи хэл дээр ирүүлэх

Өргөдлөө дараах хаягаар илгээнэ үү: **Хаяг:** Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар, Хүүхдийг Ивээх Сан. (Хүнсний 20-ын Мөнгөнзавъяагийн ард, 23 сургуулийн урд талд)

Ирүүлэх бичиг баримтуудыг PDF болгон дараахь имэйлээр 2025 оны 8-р сарын 15, 17.00 цагаас өмнө ирүүлнэ: mongolia.jobs@savethechildren.org. Шаардлага хангасан Зөвлөх багтай бид эргэн холбогдоно. Баярлалаа.

8. Тайлагналт, хяналт

Зөвлөхүүд Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын төслийн зохицуулагчид тайлагнана. Хүүхэд хамгааллын баг нь тус зөвлөхүүдийг ерөнхий удирдамжаар хангаж, гол оролцогч талуудадтай ажиллах боломжийг олгож, үе шат бүрт үр дүнг хянан үзэх болно.